

<sup>29</sup> Г. Сүхбаатар. «Монголчуудын эртний өвөг». УБ., 1980. , 97-р тал

<sup>30</sup> М Зэнээ. Дурдсан зохиол. УБ., 1987., номоос үзнэ үү.

<sup>31</sup> К. Маркс, Ф. Энгельс. Об искусстве» т. П. 1957, 559-р тал

## МАНЖИЙН ҮЕИЙН МОНГОЛЫН НОЁДЫН ЗЭРЭГ ХЭРГЭМ

А. Дашдэмбэрэл

Манжид эзлэгдэхийн өмнө халхын ноёд үйзэн өлзийт, мэргэн, цэцэн, далай, дайчин, илдэн хошууч, хөндлөн бошогт, цэцэн жонон, түшээт, эрх тайж, дархан хунтайж зэрэг цолтой байсны гадна хятад гаралтай ван, гүн, тайж гэх мэтийн хэргэм цол нэлээд дээр үед ч байсан бололтой.

Монголын түүх, сурвалж зохиолуудаас үзэхэд монгол аймгууд анхны төр улсаа байгуулан феодалын түрүү үеийн хөгжилтэй үедээ бусад аймаг улсуудын эсрэг дайн байлдаа хийдэг байжээ. Хөрш зэргэлдээ орших эртний соёлтой хятад улсруу байнга уулгалан довтолдог байсан учраас хятадын хаад монгол аймаг улсуудтай эвтэй найртай байхын тулд их хэмжээний бэлэг сэлт барьж, хэлэлцээр байгуулан хамгийн хүндтэй цол хэргэмээ шагнасан олгодог байв.

Монголын анхны төр улс Хүннү-гийн хаан Модун шаньюй улсаа гурван хэсэгт хувааж төвийн хэсгийг өөрөө захирч, зүүн баруун этгээдийг жуки ван, лули ван нарт захируулдаг байжээ<sup>1</sup>.

147— 167 оны үед Хятадын Хан улсын хаан Сяньбийн толгойлогч Таньшихуайд ван хэргэм шагнаж, найрамдал байгуулахыг оролдож байсны гадна түүний хүү Кэбинынд Вэй улсын ван хэргэм шагнаж байв.<sup>2</sup> Мөн нирун (жужан) улсын үед ч ван хэргэмтэй ноён хэд хэд байсан мэдээ бий. Харин Түрэг, Уйгар, Киргис, Киданы үед ван цолтой ноёд байсан мэдээ ховор байна.

Хамаг Монголын ханлигуудын үед 1194 онд Алтан улсын Вангин Чинсан Татарын Мэгүжин сүүлтийг үг даахгүй боллоо хэмээн цаанаас цэрэглэж, Чингис хаан бас татаруудаас эцэг, өвгөдийнхөө өсийг авах гэж хэрэйдийн хаан Тоорилтой наанаас цэрэглэж Мэгүжин сүүлтийг алав. Вангин Чинсан үүнд ихэд баярлаж, Чингис хаанд «Чаутхури» гэдэг цол, Тоорилд ван цол өгчээ. Үүнээс эхлэн хэрэйдийн хан Тоорилыг ван цолтой хамтруулан Ван хан гэх болсноос хойш Тоорил нь ван хан гэж алдаршжээ<sup>3</sup>. Тэр үед монгол аймгуудын дотор хэрэйдийн Тоорилоос өөр ван цолтой хүн байгаагүй юм. Энэ ван цол нь Зүрчидийн Алтан улсаас олгосон болой.

Монголын нэгдсэн төрийг байгуулсны дараа улаагчин үхэр жил (1217) Чингис хаан Сартуулыг биеэр дайлах болж, жин юан буюу Алтан улсыг дайлах хэргийг Мухулайд тусгайлан тушаав. Тэр жилийнхээ намар нь зарлигаар дэлхий дахины цэргийн их өрлөг мужуудыг ерөнхийлөн захирсан тайш, улсын ван (го ван)-гийн хэргэм зэрэг өгч

захируулахаар өргөмжлөөд цээр эвхмэл, алтан тамга шагнан зарлиг болруун: «Үе улиран тасалдуулахгүй, үрийн үр, ургийн ураг залгамжтугай» хэмээв.

Урьд Мухулай Алтан улсыг дайлан явж байхад Алтан улс түүнийг улсын ван гэж өргөмжлөн дууддаг байжээ. Чингис хаан үүнийг сонсоод «Сайн эр билээ» гээд түүнийг тэгж өргөмжилсөн ажээ.<sup>4</sup> Энэ нь нэгдсэн улс байгуулагдсанаас хойш Монголын их хааны зарлигаар улсын цол хэргэм болгон анх удаа ван хэргэм олгосон нь энэ болой. Үүнээс хойш эзлэгдсэн газар орныг захирах хааны удмын үр хүүхдүүдэд ван хэргэм олгон илгээдэг болжээ. Өгэдэй хааны үеэс монголд ван цолтой ноёл, олон болсон. Энэ нь монголын байлдан дагууллын дүнд бусад олон орныг эрхшээлдээ оруулсантай холбоотой.

Юан улсын үед Цзинь ван, цин ван, хэнин ван, олон ван гэх мэтийн вангууд байсан бололтой. Түүхч Д. Гонгор агсны «Халх товчоон» хэмээх томоохон бүтээлд «1295 онд хэнин ванг Манжидайн харъяат Хонгиродын ядууд цаасан пиу 18 түмэн хэсэг, олон ван Ринчений аймагт цаасан пиу 20 түмэн хэсэг, олон ван Буянчир, Миши гүнж нарын аймагт торго 9 түмэнт энтэй, жин ван Гамалын харъяанд цаасан пиу 10 түмэн хэсэг олгожээ» гэжээ. Манайд хятад нэрийг галиглан буулгах тогтсон толь бичиг байхгүй учир түүхчид өөр өөрсдийн дуудлагаар буулган бичиж байгаагаас нэг ижил нэр хоёр өөрөөр бичигдэх нь тохиолдоно.

Түүхч Ч. Далай «Юан гүрний үеийн монгол» номдоо Юан гүрний үеийн вангуудын талаар нэлээд дэлгэрэнгүй тайлбарлажээ. Үүнд: Юан улсын сударт «Цзинь ван гэдэг нь ганцхан хүн байх ёстой бөгөөд «язгуур улсын ван» гэсэн утгатай. «Цзинь» гэдэг үгийн утга бол «эх», «Язгуур», «худам» гэсэн үг. Хятадын түүхэнд баруун Цзинь, зүүн Цзинь, хойт Цзинь гэх мэт олон улс төр тогтож байсан. Тэдгээр нь тус бүр өөрсдийгөө язгуур угсаагаа жинхэнэ ёсоор залгамжилсан улс гэж үздэг байжээ. Юан гүрний үед уугуул монгол нутгаа захирч байсан ганцхан Цзинь ван байсан нь ийм учиртай аж. Иймээс Цзинь ван гэдэг нь монголоор язгуурын ван буюу язгуурын улсыг захирах ван гэсэн утгатай.

Цин ван гэдэг нь угсаа төрлийн ван гэсэн утгатай. Тан улсын хаан төрсөн дүү буюу хүүдээ хувь таслаж өгөөд Цин ван болгодог байж. Энэ нь Сүн, Юан, Мин-гийн үед уламжлагдан хэрэглэгдэж байсаар Манж дайчин улсын үед их олон болсон. Энэ ван явсаар жонон болсон нь ч үнэн. Юан гүрний үед цин ван цолтой олон хүн байсан бөгөөд үүнийг том ван бүгд 45 гэж Юан улсын сударт бичсэн байна. Юан гүрний үеийн Цин ван буюу угсаа төрлийн ван нь Цзинь ван буюу язгуурыг захирах ванд захирагдаагүй монгол нутгийн үндсэн хэсгийг буюу мөн хятад зэрэг эзлэгдсэн орны зарим газрыг захирдаг байжээ.<sup>5</sup>

Хятад гаралтай ван цол хэргэмээс гадна гүн, тайж зэрэг цол хэргэм ч нэлээд дээр үеэс монголын ноёдод хүртээж байсан мэдээ бий.

1691 онд Энх амгалан хаан ар монголыг эрхэндээ оруулан аваад монголын жонон ноён гэх мэт хуучин цол хэргэмийг халж манжийн хааны эрхэм дээд хэргэм гэгдэх чин ван, жүн ван, бэйл, бэйс, улсын түшээ гүн, улсад туслагч гүн цолыг олгох болжээ.

1691 онд Долнуурт болсон чуулган дээр Дайчин улсын Энхамгалан хааны гаргасан зарлигт: «...Халхын жонон ноён цолыг хасч ван, бэйл, бэйс, гүн, тайж, хэмээн өргөмжилж, хошууны эзэн засгийг хавсруул сугай! Эдгээр өргөмжлөгдсөн ван, бэйл, бэйс, гүн, засаг, тэргүүн зэрэг тайжид цөм пүнлүүний мөнгө, торго шагнаж хүртээхийг дотоод монголын хууль ёсоор явуулсугай! Халхын гурван хан цолыг хэвээр

өргөмжилж засаг тамга, пүнлүү олгуулахгүй, хуучин ёсоор есөн цагааны алба барьж эрх ашгийг хэвээр агуулсугай! Өндөр гэгээнийг шашныг мандуулах Жавзандамба хутагт өргөмжилж халх бүхний үе улиран тахих багш лам болгосугай!» гэжээ. Энэ чуулганаар Энхамгалан хаан халх монголын 35 ноёд цол хэргэм шагнаж 34-ыг нь хошууны засаг ноён болгоход монголын 3 ханаас гадна хошой чин ван 3, төрийн жүн ван 6, төрийн бэйл 3, хошууны бэйс 4, засаг 1, түшээ гүн 1, туслагч гүн 6, тэргүүн зэрэг тайж 6-г шагнаж<sup>7</sup> дотоод монголын ноёдын адилаар пүнлүү, торго олгохоор болгожээ.

Манжийн ноёд, дотоод монголын хорчины ноёд, гадаад монголын ноёдын авах пүнлүүний хэмжээ хоорондоо их л ялгаатай байсан.

Манжийн үеийн монголын ноёд эзлэх эрх, ямба, авах цалин пүнлүү, хангамж зэргээр ихээхэн ялгаатайгаас гадна өмсөх дээл хүрэм, малгайн оройд зуух отго, жинс, зэрэг гадаад байдлаараа ялгагдана.

Чин ван-манжийн хаанаас монголын ноёдод олгосон хамгийн том хэргэм, малгайн оройд улаан эрдэнийн чулуун жинс тогтоож, жинсний суурьт хоёр зэрэг алтан луу ороож, дунд нь 10 тана шигтгэнэ. Малгайн өмнө хадсан магнайвчид 5 тана, малгайн хойт талд хадсан алтан цэцэгт 4 тан шигтгэнэ. Дээлэнд нол магнаг буюу луут торгыг хэрэглэнэ. Гадаад энгэр, ханцуй, туурь, захыг номоор мөшгөөрлөж, өвөл булгаар хажиллуулна. Пүүзэт хүрмэнд дөрвөн дүгэрэг луутай байх бөгөөд өмнө ба хойтод төв эсрэг луу, зуун баруун этгээдэд зөрүү дуутай байна. Өвөл цагт булган дэвсгэр хэрэглэнэ<sup>8</sup>. Чин ван 2000 лан мөнгө, 25 зах торгоны пүнлүү авах бөгөөд Цян Чин мэнд жасаалах алба тохиолдвоос хоол хүнс зэрэгт хэрэглэхийн тулд 430 лан<sup>9</sup> мөнгөний шагнал авна. Манжийн хуулинд зааснаар 60 хамжлага захирна.

Жүн ван-Малгайн оройд улаан эрдэнийн чулуун жинс тогтоож, дунд нь 8 тана шигтгэнэ. Зун цагийн ёст малгайн магнайвчид 4 тана, хойт талын алтан цэцэгт 3 тана хадна. Чин вангийн адил торгон дээл өмсөх ба пүүзэт хүрэм нь дүгэрэг зөрүү муутай байна. Өвлийн цагт булгаар хажсан шилүүсний арьсан дэвсгэр хэрэглэнэ. Жүн ван 1500 лан мөнгө, 20 зах торгоны пүнлүү авах бөгөөд Цян Чин мэнд жасаалах албанд явахдаа 317 лан мөнгөний шагнал авах бүлгээ. 50 хамжлага захирна. Хан, вангууд гурван нүдтэй тогосын отго малгайд зүүсэн байна.

Бэйл-малгайн оройд улаан эрдэнийн чулуун жинс тогтоож дунд нь 7 тана шигтгэнэ. Зун цагийн ёст малгайн өмнөдөд магнайвч хадуулж 3 тана, арын алтан цэцэгт 2 тана хадаж хоёр нүдэт тогосын отго зүүнэ. Өнгөт магнагаар хийсэн дээл өмсөж, хоёр дүгэрэг төв эсрэг аварга могой бүхий пүүзэт хүрэм өмсөнө. Өвлийн цагт шилүүсэн дэвсгэр хэрэглэх болой.

Бэйл 800 лан мөнгө, 13 торгоны пүнлүү авах бөгөөд Цян Чин мэнд жасаалах үед 238 лан мөнгөний шагнал авна. Манжийн хуульд зааснаар 40 хамжлага захирах эрхтэй.

Бэйс-Малгайн оройд эрдэнийн чулуун жинс тогтоож хоёр нүдэт тогосын отго зүүсэн байна. Ёст малгайн жинсний суурьт 6 тана, зун цагийн ёст малгайн өмнөдөд магнайвч хадуулж 2 тана, хойдох алтан цэцэгт 1 тана шигтгэнэ. Өнгөт магнагаар хийсэн дээлэн дээр, 2 дүгэрэгтэй, хөндлөн аварга могой бүхий пүүз өмсөнө. Жилийн пүнлүү 500 лан мөнгө, 10 торго авах бөгөөд Цян Чин Мэнд жасаалах үед 150 лан мөнгө шагналд авна. Өвлийн цагт цагаан ирвэсэн дэвсгэр хэрэглэж, 35 хамжлага захирна.

Улсын түшээ гүн- малгайн оройд эрдэнийн чулуун жинс тогтоож, жинсний сууринд 5 тана, зун цагийн ёст малгайн Өмнөдөд магнайвч

хадуулж 1 тана, хойнох алтан цэцэгт нэг оюу шигтгэнэ. Бэйл, бэйсийн адил өнгөт магнаг дээл өмсөж хоёр өнцөгтэй эсрэг аварга могой бүхий пүүзэт хүрэм хэрэглэнэ. 30 хамжлага захирч, 300 лан мөнгө, 9 торгоны пүнлүү авна<sup>10</sup> Цян Чин мэт жасаалах үе 117 лангийн шагнал нэмж авна. Өвлийн цагт улаан өнгийн ирвэсэн дэвсгэр дэвсэнэ.

Улсад туслагч гүн-малгайн жинсий сууринд 4 тана шигтгэж, оройд эрдэнийн чулуун жинс тогтооно. 200 лан мөнгө, 7 торгоны пүнлүү авах бөгөөд Бэйл, бэйс, түшээ гүнгийн адил өнгөт магнаг дээл өмсөх бөгөөд хоёр өнцөгт зөрүү аварга могой бүхий пүүзэт хүрэм өмсөнө. Бусад нь бүгд түшээ гүний адил байна.

Мөн 4 зэргийн тайж, 9 зэргийн түшмэдийн авах цалин пүнлүү, эдлэх эрх ямба, дагах хөтөч, унах унаа, захирах албат бүгд л зэрэг дэвээрээ ялгагдана.

Тэргүүн зэргийн тайж 15\* хамжлага<sup>11</sup> захирч байхад дөтгөөр зэргийн тайж 4 хамжлага захирах жишээтэй. Цаана нь хаад ноёдын хатад, авхай нар, гүнж, тавнангууд гээд олон зэрэг дэв бүхий ноёд ноёгтой нар зэрэг дэвээр ялгаатай пүнлүү хангамж авч байсныг алийг тоочиж барах билээ.

Манжийн хаанаас монголд олон засаг хошуу байгуулж тэднийг захирсан хошуу ноёд, түүний үр хүүдүүд, хатад, тавнан гүнж нарт өндөр хэргэм зэрэг хүртээн улсын сангаас жилийн пүнлүүний мөнгө, торго, үнэт эд, эрдэнэсийн бэлэг сэлт өгч байсан нь манжийн хааны өглөгч энэрэнгүйг харуулах гэсэн мэт боловч монголчуудын хөрөнгөөр хэдхэн тооны хаад ноёдыг тал засан өөртөө татаж, номхон хүлцэнгүй захиран барьж байх гэсэн манжийн хаадын ов мэх билээ.

Энэ их пүнлүү торго, үнэт эрдэнэ, ангийн үнэт үс нь монголын ард түмний зовж зүдэрч өсгөсөн таван хошуу мал, ан амьтан, байгалийн баялаг бүхлээрээ манжийн хааны санд элдэв төрлийн алба татвар, бэлэг сэлт, хээл хахууль болгон гувчуурлан татаж оруулсан их хөрөнгөний өчүүхэн хэсэг нь билээ.

Өндөр хэргэм зэргээр шагнуулж, үнэтэй торго дурдан өмсөж, найр цэнгэлд бялхаж байсан монголын ноёд манжийн дарлалд байсан урт удаан хугацаанд дандаа л жаргасаар дураараа туйлж байсан уу гэвэл тийм бишээ. Тэдний хөдлөх гишгэх, дуугарах бүхэн нь манжийн хуулиар зохицуулагдаж өчүүхэн боловч осолдвол хатуугаар цээрлүүлэн шийтгүүлдэг байсан. Гэхдээ энэ нь ард түмэнд оногдох хүнд, шийтгэлээс их л ялгаатай даа.

<sup>1</sup> БНМАУ-ын түүх (Нэмж засварласан гурав дахь удаагийг хэвлэл). УБ. 1984. 115-116-р тал.

<sup>2</sup> БНМАУ-ын түүх. Гурван боть. Тэргүүн боть (нэн эртнээс XVII зуун). УБ. 1966, 99-р тал.

<sup>3</sup> Б. Баганын орчуулга. Тэмүжиний есөн өрлөг. Хайлар. Синхуа. 1984. 38-р тал. (Хуучин үсгээр).

<sup>4</sup> Мөн тэнд, 8-р тал.

<sup>5</sup> Ч. Далай. Юан гүрний үеийн монгол. УБ. 1973. 67-р тал.

<sup>6</sup> Зарлигаар тогтоосон гадаад монголын хотон аймгийн ван гүнгийн илтгэл шаштир. 45-р дэвтэр.

<sup>7</sup> Д. Гонгор «Халх товчоон». УБ. 1970. 252-р тал.

<sup>8</sup> Дайчин улсын бүгд хуулийн бичиг 40-р үг.

<sup>9</sup> Л. Дэндэв. Манжаас монголыг колоничилсон үеийн түүхт хэрэглэгдэхүүн, Түүхийн хүрээлэн. Гар бичмэл [хуучин үсгээр]. II-р тал.

<sup>10</sup> Зарлигаар тогтоосон дайчин улсын бүгд хуулийн бичиг. 18-р дэвтэр.

\* «БНМАУ-ын түүх нэгэн боть УБ. 1966 192-р тал БНМАУ-ын түүх Нэмж засварласан гурав дахь удаагийн хэвлэл. УБ. 1984. «БНМАУ-ын түүхийн сурах бичиг» зэрэгт тэргүүн зэргийн тайж 60 хамжлага... гэж ташаарсан буй.

<sup>11</sup> Ш. Нацагдорж Сүм, хамжлага, шавь ард. УБ. 1972.